



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1190

Улаанбаатар хот

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 39,200,000.0 /гучин есөн сая хоёр зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай старекс маркийн 05-47 УНС улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн Түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал авто-2020

11500000349